

ТУЗ-ЫН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН АЖЛЫН ТАЙЛАН

Компанийн нэр: “Си И Си инвестмент ББСБ” ХХК

Регистрын дугаар: 5765919

Тайлангийн хугацаа: 2025.01.01-12.31

Нарийн бичгийн даргын нэр: Х.Батцэцэг

Contact:

T: (976) 7575 5511
M: ceci@upg.mn
W: www.ceci.mn

Location:

3F, Monnis Building, Stadium Orgil-22,
Great Mongolian street, 18th khoroo,
Khan-Uul district, Ulaanbaatar 17011, Mongolia

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралдааны төлөвлөлт, зохион байгуулалт, протокол хөтлөлт.

Компани 2025 онд 4 удаагийн биет хурлыг зохион байгуулсан бөгөөд, хурлыг төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмын дагуу зохион байгуулж, хурлын протокол болон шийдвэрүүдийг хөтлөн албажуулж, төрөлжүүлэн архивласан.

2. Төлөөлөн удирдах зөвлөл/хороодын шийдвэрийн хэрэгжилтэд мониторинг хийх, дагаж мөрдүүлэх зохицуулалт.

Төлөөлөн удирдах зөвлөл болон хороодын шийдвэр, хугацаатай өгсөн үүрэг даалгаврын биелэлтэд хяналт тавьж, хугацаанд хэрэгжүүлэх дээр тодорхой арга хэмжээ авч ажилласан. Үүнд:

- Төлөөлөн удирдах зөвлөлд хугацаа хэтэрсэн, эргэлзээтэй, муу зээлийн мэдээг сар бүр тогтмол хугацаанд танилцуулж байна.
- Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодыг шинэчлэн байгуулж, аудитын хорооны журмыг шинэчлэн батлуулсан.
- Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооноос дотоод аудитын баг томилж, хяналт шалгалт хийж, шалгалтын үр дүн зөвлөмжийг компанид хүргүүлэн ажилласан.
- Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх эрсдлийн удирлагын хороог шинэчлэн байгуулж, компанийн эрсдлийн бүртгэл, эрсдлийг бууруулах арга хэмжээтэй танилцан цаашид эрсдлээс хамгаалах, эрсдлийг бууруулах зөвлөмж гарган 2026 онд хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

3. Баримт бичгийн стандарт, хадгалалт, ил тод байдлыг хангах.

-Баримт бичгийн стандарт, хадгалалт, архив болон төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж ажиллав.

4. Хуулийн болон зохицуулалтын мэдээлэл солилцоо дэмжих.

Хууль, зохицуулалтын шинэчлэлтэй холбоотой мэдээллийн солилцоог зохион байгуулж, мэдээллийг холбогдох нэгжүүдэд шуурхай дамжуулж, мэдээллийн солилцоог дэмжин ажиллав.

Огноо	Хуралдааны төрөл	Ирц (%)	Хэлэлцсэн асуудал	Гаргасан шийдвэр
2025.01.21	Биет хурал	100%	1.Өмнөх хурлаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн талаар мэдээлэл өгөх 2.Компанийн 2024 оны үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайлан танилцуулах 3.Гадаад орчны судалгаа болон ББСБ-ын салбарын тайлан 4.Компанийн 2025 оны бизнес төлөвлөгөө танилцуулах	Компанийн 2025 оны бизнестөлөвлөгөөг батлахаар шийдвэрлэв.
2025.04.24	Биет хурал	100%	1.Компанийн 2025 оны 1-р улирлын үйл ажиллагааны тайлан 2.Компанийн дунд хугацааны стратегийн хувилбарын танилцуулга	LOS,LMS, кредит карт болон киоскын судалгааг илүү дэлгэрэнгүй хийж, зардал үр ашиг, эрсдлийг тооцоолж дахин танилцуулахыг үүрэг болгон шийдвэрлэв.

Огноо	Хуралдааны төрөл	Ирц (%)	Хэлэлцсэн асуудал	Гаргасан шийдвэр
2025.05.27	Биет хурал	80%	1. Компанийн 2025 оны бизнес төлөвлөгөөнд оруулсан өөрчлөлтийг хэлэлцүүлж, батлах 2. Компанийн зээлийн үйл ажиллагааны систем болон зээлийн удирдлагын системийн шинэчлэлт, шинэ системийн худалдан авалт, нэвтрүүлэлтийн төлөвлөгөө танилцуулах	1. Компанийн 2025 оны хоёрдугаар хагасын бизнес төлөвлөгөөг шинэчлэн батлахаар шийдвэрлэв. 2. Компани зээлийн үйл ажиллагааны LOS, LMS нэвтрүүлэх, шаардлагатай системийг худалдан авахыг зөвшөөрч шийдвэрлэв.
2025.09.03	Биет хурал	100%	1. 2025 оны хагас жилийн гүйцэтгэл 2. Төслүүдийн явц 3. Бизнес төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах тухай	1. Эрэн сурвалжлагдаж байгаа, эргэлзээтэй болсон, чанаргүй зээлийн мэдээлэл бэлтгэхийг даалгав. 2. Өрсөлдөгч нарын зээлийн хүүний судалгаа улирал тутам хийж, өөрсдийн хүүний өөрчлөлтийг улирал тутам шинэчилж байхыг даалгав. 3. Бизнес төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах саналыг дэмжиж шийдвэрлэв.

Огноо	Шийдвэрийн агуулга	Хариуцагч	Төлөв (төлөвлөсөн/ хэрэгжиж бгаа/дууссан)	Хугацаа	Тайлбар
25/001	Зээлийн шийдвэр гаргалтын эрх мэдлийн хугацааг сунгах тухай	Гүйцэтгэх удирдлага	Хэрэгжиж байгаа	2025.01.07	ТУЗ-р дахин хэлэлцэж шийдвэрлэнэ.
25/003	Компанийн төсөв батлах тухай	Гүйцэтгэх удирдлага	Хэрэгжиж байгаа	2025.01.21	
25/005	М кредит платформ хамтран ажиллах тухай	Гүйцэтгэх удирдлага	Хэрэгжиж байгаа		
25/006	Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх тухай	Гүйцэтгэх удирдлага	Дууссан	2025.05.19	
25/008	ТУЗ-ийн журам шинэчлэн батлах тухай	ТУЗ-ийн НБД	Дууссан	2025.05.21	
25/010	Нэт капитал ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулах тухай	Гүйцэтгэх удирдлага	Дууссан	2025.05.30	
25/009	Гүйцэтгэх захирал чөлөөлөх, томилох тухай	ТУЗ-ийн НБД	Дууссан	2025.05.09	
25/011	Компанийн 2-р хагасын бизнес төлөвлөгөө шинэчлэн батлах тухай	Гүйцэтгэх удирдлага	Хэрэгжиж байгаа	2025.05.30	

Огноо	Шийдвэрийн агуулга	Хариуцагч	Төлөв (төлөвлөсөн/ хэрэгжиж бгаа/дууссан)	Хугацаа	Тайлбар
25/012	Цалин урамшууллын болон нэр дэвшүүлэх хороо байгуулах тухай	ТУЗ-ийн НБД	Дууссан	2025.05.29	
25/014	Аудитын хороо байгуулах тухай	ТУЗ-ийн НБД	Дууссан	2025.06.02	
25/016	Итгэлцлийн гэрээ байгуулах тухай	Гүйцэтгэх удирдлага	Хэрэгжиж байгаа	2025.06.13	
25/017	Ур чадварын шаардлага батлах тухай	Цалин урамшуулал болон нэр дэвшүүлэх хороо	Хэрэгжиж байгаа	2025.06.17	
25/018	Урамшуулал тооцож олгох тухай	Цалин урамшуулал болон нэр дэвшүүлэх хороо	Төлөвлөсөн	2025.06.17	
25/019	Андеррайтер зуулчлалын гэрээ байгуулах тухай	Гүйцэтгэх удирдлага	Хэрэгжсэн	2025.06.19	
25/021	Зээлийн хорооны гишүүн чөлөөлөх, томилох тухай	Цалин урамшуулал болон нэр дэвшүүлэх хороо	Дууссан	2025.07.01	

Огноо	Шийдвэрийн агуулга	Хариуцагч	Төлөв (төлөвлөсөн/ хэрэгжиж бгаа/дууссан)	Хугацаа	Тайлбар
25/022	Салбарт зээл шийдвэрлэх эрх олгох тухай	Гүйцэтгэх удирдлага	Дууссан	2025.07.02	
25/025	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тухай бэлтгэл хангах тухай	Гүйцэтгэх удирдлага	Дууссан	2025.06.23	
25/027	Компанийн 2025 оны бизнес төлөвлөгөө шинэчлэн батлах тухай	Гүйцэтгэх удирдлага	Хэрэгжиж байгаа	2025.09.03	
25/028	Эрсдлийн удирдлагын хороо байгуулах тухай	ТУЗ-ийн НБД	Дууссан	2025.09.23	
25/030	ТУЗ-ийн дэргэдэх аудитын хорооны журам батлах тухай	Аудитын хорооны нарийн бичгийн дарга	Хэрэгжсэн	2025.11.04	
25/32	Төлбөрийн баталгаа гаргах тусгай зөвшөөрөл хүсэх тухай	Гүйцэтгэх удирдлага	Төлөвлөсөн	2025.12.22	

2025 онд ТУЗ-р 5 зээлийн хүсэлт шийдвэрлэгдсэн байна. Үүнээс нэг зээл хаагдсан байгаа.

1. Хуралдааны тэмдэглэл, тогтоол, тушаалын бүртгэл (код, огноо, хадгалалтын байршил).

ТУЗ-ийн хурлын материалууд болон тогтоол, шийдвэрүүдийг файл байдлаар үүлэн технологи

- (MS365 One drive)-т хадгалдаг. Файлыг багцалж folder буюу хавтас үүсгэн цахим хэлбэрээр хадгалахдаа он тус бүрээр, он дотроо төрөл (хурлын материал, тогтоол шийдвэр, дүрэм журам гэх мэт) тус бүрээр ялган хадгалдаг.
- Цаасан баримт бичгийг зориулалтын хатуу А4 хавтсанд цахим файл хадгалсаны адилаар төрөлжүүлэн хадгалдаг.

2. Хувьцаа эзэмшигчид болон олон нийтэд нээлттэй байршуулсан материалын жагсаалт/линк

Компанийн www.cesi.mn цахим хаягт хувьцаа эзэмшигч болон олон нийтэд нээлттэйгээр доорхи мэдээллүүдийг байршуулан танилцуулсан. Үүнд:

- Компанийн танилцуулга;
- Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн танилцуулга;
- Төлөөлөн удирдах зөвлөлийн тайлан;
- Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодын тайлан;
- Компанийн үйл ажиллагааны тайлан;
- Санхүүгийн аудитлагдсан тайлан;
- Хүний нөөцийн төлөвлөлт бодлого;
- Засаглалтай холбоотой дүрэм журмууд.

1. Төлөөлөн удирдах зөвлөл/хороодын журам, бодлогын шинэчлэл (үүсгэсэн санал, баталсан эсэх).
 - Төлөөлөн удирдах зөвлөлийн журмыг 2025 оны 5 сарын 21-ний өдрийн 25/008 тоот тогтоолоор шинэчлэн баталсан.
 - Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх “Аудитын хороо”-ны журмыг 2025 оны 11 сарын 4-ний өдрийн 25/030 тоот тогтоолоор баталсан.
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн чиглүүлэх/дахин сургалт зохион байгуулсан байдал.
 - Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сургалтанд хамруулах сургалтын төлөвлөгөө батлуулсан бөгөөд төлөвлөгөөний дагуу гишүүнийг “Мэдээллийн аюулгүй байдал дотоод аудит”-ын сургалтанд хамруулсан.

Тайлан бэлтгэсэн:

Нарийн бичгийн дарга: Х.Батцэцэг /  /

Огноо: 2025.12.27